

## ДУНДГОВЬ АЙМГИЙН ИТХ, ЗДТГ-ЫН 2019 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

### НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 5-р хуралдаан 2019 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр болж хуралдаанаар:

1. Улсын бүртгэлийн хэлтсийн 2018 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, 2019 онд дэвшүүлсэн зорилт
2. Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрийн 2018 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, 2019 онд дэвшүүлсэн зорилт
3. Дундговь аймгийн байгалийн ургамлын менежментийн төлөвлөгөөг батлах тухай
4. Хүнсний ногоо дэд хөтөлбөрийг батлах тухай
5. Жимс жимсгэнэ аймгийн дэд хөтөлбөр, төлөвлөгөө
6. Үндсэн хөрөнгө блансаас блансад шилжүүлэх тухай
7. Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай
8. Хөрөнгө акталж, данснаас хасах тухай
9. Алдарт эхийн 1,2-р одонгоор шагнуулах тухай
10. Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнуулах тухай

**Дундговь аймгийн түүхийн дурсгалт газруудын талаар нэвтрүүлэг хийгдэнэ.** Дундговь аймгийн ИТХ-ийн дарга С.Сүхбаатар, засаг дарга О.Бат-Эрдэнэ нартай ажлын хэсэг 2019 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр Өлзийт суманд ажиллаа. Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт байрлах байгалийн үзэсгэлэнт газар "Цагаан суврага", олон зууны түүхийн нууцыг агуулсан Дэл уулын хадны бичээс, сүг зургийн тухай нэвтрүүлгийн бэлтгэл ажлыг хангалаа.

**Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн "Байгалиа хамгаалъя" аян 2019 оны 4 дүгээр сарын 15-нд эхэллээ.** Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн "Байгалиа хамгаалъя" сарын аяныг зохион байгуулах ажлын хэсэг хуралдаж аймгийн ГХУСАЗСЗ, МХГ, БОАЖГ, ЦГ, ОБГ, МУЗЕЙ, "ИХ ГАЗРЫН ЧУЛУУ" БЦТХГ, УЦУОША, ГХБХБГ, БТСГ хамтран зохион байгуулахаар болж ажлын төлөвлөгөөг батлан **"БАЙГАЛИА ХАМГААЛЪЯ" нэгдсэн өдөрлөгийг** хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй "БАЙГАЛИА ХАМГААЛЪЯ" нэгдсэн арга хэмжээг 2019.04.23-ны өдөр холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Арга хэмжээнд оролцсон төрийн албан хаагчид, иргэд олон нийтэд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, мэргэжлийн байгууллагуудын хамтын үйл ажиллагаа, цаашид авах арга хэмжээний талаар мэдээлэл хийж, урьдчилан сэргийлэх гарын авлага, санамж сэрэмжлүүлэг тарааж ажиллалаа.

#### **Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурал:**

Засаг даргын Зөвлөлийн хурал 4 дүгээр сард 2 удаа хуралдаж нийт 13 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Хурлаар Дундговь аймгийн хөгжлийн загвар боловсруулах ажлын явцтай танилцаж зөвлөлийн гишүүдийн саналыг тусган "Аймгийн хөгжлийн загвар" боловсруулах ажлыг 1 сарын хугацаанд бүрэн дуусгах үүрэг өглөө. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч барагдуулах, шийдвэрлэлтийн хяналт тавих, мэдээлэх журмын төслийг хэлэлцэн зөвлөлийн гишүүдээс журмын төсөлд саналыг тусган зөвлөлийн 8 дугаар хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар шийдвэрлэв.

Мөн “Үндэсний бичиг үсгийн баяр-2019” Монгол бичгийн их сорилго уралдаанд дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах, Дундговь аймгийн музейн түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогын ажлын тайлантай танилцаж, Волейболын спортын Олон улсын хэмжээний мастер Монхорын Гаамаагийн нэрэмжит “Дундговь нутаг сайхан” волейболын нээлттэй тэмцээнд дэмжлэг үзүүлэх, хүндэтгэл үзүүлэх, буцалтгүй тусламж үзүүлэх г.м асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Аймгийн ИТХ-ын дарга С.Сүхбаатар, Засаг дарга О.БатЭрдэнэ нар хамтын ажиллагаатай БНСУ-ын Гуянг хотын даргын урилгаар 2019.04.25-28-ны өдрүүдэд Гуянь хотын цэцэгийн баярт оролцон хамтын ажиллагааны гэрээний хугацааг 2-3 жил сунгаж хамтран ажиллахаар ярилцлаа.

2019.04.17-19-ны Аймгийн ЗДТГ-ын дарга Ц.Эрдэнэсүрэн ОХУ-ын Улаан үд хотод болсон үзэсгэлэн худалдаанд оролцож Уяхан замбативийн наран урлагийн наадмын сурталчилгааг хийсэн байна.

2019.04.23-ны өдөр БНХАУ-аас Монгол Улсын Дорноговь аймгийн Замын Үүд суманд суугаа Ерөнхий консулын газрын ерөнхий дэд консул Дундговь аймагт ажлын айлчлал хийж 2019 онд хамтран ажиллах чиглэлийн талаар санал солилцон аймгийн БТСГ-ын Тайковондогийн холбоонд дэвжээний санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэн гардуулан өгсөн байна.

Аймгийн Засаг дарга МУ-ын Шадар сайдтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийн бэлтгэл ажил хийгдэж байна

### **ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

“Тогтвортой амжиргаа 3” төслөөс сумдын орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх “чиглүүлэгч” бэлтгэх сургалт, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газар Дэлхийн банк, азийн хөгжлийн банктай хамтран “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын аргачлал, цахим системийг ашиглах” сургалтанд хэлтсийн мэргэжилтнүүд хамрагдлаа.

“Говь-Угтаал сумын спорт заалны барилга”, “Аймгийн төвийн хатуу хучилттай 2.8 км зам”, “Адаацаг сумын ЕБС-ын Биеийн тамирын талбайн тохижилтын ажил”, “Луус сумын 80 ортой сургуулийн дотуур байрны ажил”, “Аз жаргалын төгөл 100 га ойн зурвасын усалгааг цэвэр усны төвлөрсөн системд холбох ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерүүдийг тус тус зарлаж Аймгийн ИТХ-ын албан хэрэгцээнд автомашиныг нийлүүлэх тендер шалгарсан Мөнххада ХХК-тай 4 дүгээр сарын 8-ны өдөр 199,5 сая төгрөгийн гэрээ байгууллаа.

Хот тохижуулах ОНӨААТҮГ-ын албан хэрэгцээнд автомашин нийлүүлэх ажлын 44 сая төгрөг, ИТМ-2019- Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож, орон нутгаа сурталчлах төслийн 2,5 сая, Аймгийн ИТХ-ын автомашины 199,5 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг нээсэн.

2019 оны 4 дүгээр 2-ны өдрийн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар Аймгийн ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хөрөнгийг Шүүхийн шинжилгээний албанд, Аймгийн ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хөрөнгийг Сайнцагаан сумын ЭДЦС, Их Газрын Чулууны Байгалийн Цогцолборт Газрын захиргаанд, Аймгийн ИТХ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хөрөнгийг Цагдаагийн газарт балансаас балансад шилжүүлэх, БОАЖГ, Аймгийн Ахмадын хорооны үндсэн хөрөнгө бэлтгэх тухай, Өндөршил сумын ЗДТГ-ын бага оврын трактор, зоорийг акталж, данснаас хасах зөвшөөрөл авах тухай асуудлуудыг оруулж, хэлэлцүүлэн батлууллаа.

2019 оны 4 дүгээр сарын 8 ны өдрийн эд хөрөнгийн дуудлага худалдаагаар Өлзийт сумын ЗДТГ-ын Патриот автомашиныг 7,200,000 төгрөгөөр, Нэгдсэн эмнэлгийн Донг Пенг автомашиныг 1,100,000 төгрөг, Сайнцагаан сумын 3-р багт “Тэс пертолиум” ХХК-ийн ШТС-ын

зүүн урд талд байрлах 600 м2 газрыг эзэмшүүлэх дуудлага худалдааг 2019.04.25-нд цахим биржээр зохион байгууллаа. 2 иргэн оролцож газар эзэмших эрхийн гэрчилгээг 5 сая төгрөгөөр худалдсан байна.

## **ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

### **Хууль, эрх зүйн хэлтэс:**

1. "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил", "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 11 удаагийн эрх зүйн албан бус сургалтыг иргэд, албан хаагчдад шинээр батлагдсан хууль тогтоомжуудыг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж,

2. "Авлигагүй Дундговь" аяны хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын албан хаагчдад "Авлигаас урьдчилан сэргийлэх Иргэний хяналтын зөвлөл"-ийн гишүүдээс авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, иргэд, олон нийттэй хамтран ажиллах талаар мэдээлэл хийж, тус 2 газар авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд нэгдэх арга хэмжээг үргэлжлүүлэн "Би авлига өгөхгүй, авахгүй" энгэрийн тэмдгийг гардуулж, өдөр бүрийн үйл ажиллагаанд мөрдөн хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулав.

3. Авлигатай тэмцэх газраас "Хүүхдийн шударга байдлын үнэлгээ"-г тогтоох судалгааны ажлыг 7-12 дугаар ангийн сурагчдын дунд цахим хэлбэрээр зохион байгуулж байна.

4. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагуудын дарга нараас батлан гаргасан эрх зүйн актыг хуваарийн дагуу хянах ажлыг зохион байгуулж Ус, цаг уур орчны шинжилгээний төв, Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын 2019 оны 1-4 дүгээр сард батлан гаргасан нийт 38 эрх зүйн актыг хянаж, зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

5. Аймгийн Засаг даргаас 4 дүгээр сард батлан гаргасан захирамжуудаас нийт 34 захирамжийг аймгийн [www.dundgovi.gov.mn](http://www.dundgovi.gov.mn) сайтад ил тод байршуулан сурталчлав.

### **Хууль хяналтын үйл ажиллагаа:**

6. Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагаагаар 53 төлбөр, тэтгэлгийн 153,5 мянган төгрөгийн гүйцэтгэх баримт бичигт ажиллагааг зохион байгуулан, 11 иргэний санал хүсэлтийг хүлээн авч ажилласан. Шүүхийн шийдвэрээр өр төлбөртэй эсэх лавлагааг 5 иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр гаргаж үйлчилсэн. Иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэртэй 12,3 сая төгрөгийн 42 хүн, хуулийн этгээдийн төлбөр, тэтгэлгийг төлүүлсэн. Мөн торгох ялтай 2 ялтны 2,1 мянган төгрөгийг барагдуулан орон нутгийн орлогод 9,300,0 мянган төгрөгийг төвлөрүүлэн ажилласан. Говь-Угтаал суманд 3 хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээтэй этгээдэд биечлэн хяналтыг тавих ажиллагааг зохион байгуулан ажилласан.

7. "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил"-ийн ажлын хүрээнд Нэг цэгийн үйлчилгээгээр тус сард Иргэний бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн бүртгэл, иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийг бичиг баримтаа хаяж үрэгдүүлсэн нийт 592 иргэнд бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн.

**Гэмт хэрэг, зөрчлийн талаархи мэдээлэл:** Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Цагдаагийн газраас "Нэг хором", "Нэг хором хүлээ", "Авто машин-2019", "Байгалиа хамгаалъя", "Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлье" нэгдсэн арга хэмжээг тус тус зохион байгуулж, аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран "Авто ослоор алаг үрсээ алдсаар байхуу" жагсаалыг Мандал худалдааны төвийн талбайд зохион байгууллаа.

9. Аймгийн ГХУСАЗСЗөвлөл, Цагдаагийн газар хамтран "Гэмт хэрэг зөрчилгүй жишиг сум" арга хэмжээг Гурвансайхан суманд зохион байгуулж, сургалт сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээнүүдийг авч, мөн "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сум бүрт" арга хэмжээг

Цагдаагийн газраас санаачлан аймгийн Баянжаргалан, Адаацаг сумдад зохион байгуулж ажилласан.

10. Хүүхдэд хамгааллын жил болгон зарласантай холбогдуулж ГБХЗХГ, Цагдаагийн газар, Гурвансайхан, Өндөршил, Өлзийт, Хулд, Луус сумдад “Хүүхэд хөгжил хамгаалал-2” аяныг зохион байгуулсан.

11. 4 дүгээр сард аймгийн хэмжээнд 88 гэмт хэрэг гарч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13,7 хувиар буурсан байна. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь 38,3 буюу 14,9 хувиар нэмэгдсэн. Хялбаршуулсан журмаар 208 хэргийг шийдвэрлэж, 117 гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, харьяаллын дагуу 10 хэргийг шилжүүлсэн. Зөрчлийн хуулиар 6067 хүнд арга хэмжээ авч 205,3 төгрөгийн торгууль ногдуулсан. Гэмт хэргийг сумдаар авч үзвэл Гурвансайхан, Дэлгэрцогт, Сайнцагаан, Сайхан-Овоо, Хулд, Эрдэнэдалай, Говь-Угтаал сумдад 20-100 хувиар буурсан байна. Харин Адаацаг, Баянжаргалан, Дэлгэрхангай, Дэрэн, Луус, Өндөршил сумдад 50 хувиас 2 дахин өссөн байна.

12. Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хамгаалах малгай”, “Бүс”, “Тээврийн хэрэгсэл”, “Гэрэл” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг орон нутгийн иргэд, олон нийтийн дунд зохион байгууллаа.

**Архивын ажлын мэдээлэл:** 13. МУ-ын Засгийн газрын 2000 оны 86 дугаар тогтоолын дагуу Архивын Ерөнхий газрын дэргэдэх мэргэжил олгох, дээшлүүлэх, давтан сургах сургалтын төвд суралцуулах тухай захиалгыг сум, байгууллагуудаас авч Архивын Ерөнхий газарт хүргүүлсний дагуу анхан шатны сургалтанд 1, давтан болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд 5 архив, бичиг хэргийн ажилтныг хамруулав.

14. МУ-ын Засгийн газрын 2017 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу шинээр баригдсан барилга, барилгын засвар өргөтгөлийн холбогдох зураг төсөл, техник технологийн баримт бичиг болон хувийн гаралтай баримтаар сан хөмрөгөө нөхөн бүрдүүлэх зорилгоор 2 объектын 110 ХН-ийг хүлээн авч бүртгэл жагсаалт, акт үйлдлээ.

15. Аймгийн архивын дэргэдэх Баримт Бичиг Нягтлан Шалгах Арга зүйн комисс 1 удаа хуралдаж аймгийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх байгууллагын жагсаалт, хуваарь болон сум, байгууллагын байнга хадгалах баримтын данс, бүртгэл, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, хадгалах хугацаа дууссан байгууллагын устгах хэргийн акт зэрэг 3 байгууллагын 9 асуудлыг хянан хэлэлцэн батлаж хариуг холбогдох сум, байгууллагад хүргүүлэв.

16. Хөмрөг үүсгэгч байгууллагын баримт бичигт тооллого явуулах төлөвлөгөө, график гарган ажилласнаар 4 дүгээр сард 2 хөмрөг үүсгэгч байгууллагын 1354 хадгаламжийн нэгжид иж бүрэн тооллого явуулж, тооллогын хуудас, акт зэргийг хөмрөг тус бүрээр үйлдэж 2 хувийн хэрэгт баяжилт хийж, тооллого хийсэн тухай ХН-ийн арын хуудсанд тэмдэглэгээ хийж тавиурт байрлууллаа. Үүнээс тооллогын явцад дараалал алдагдсан 10 ХН-ийг дараалалд оруулж бүртгэлд тусгалаа.

### **ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД: НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС**

1. “Уяхан замбуу тивийн наран” урлагийн их наадмын “3000 уртын дуучид, морин хуурчид”-ын тоглолтод оролцох тухай аймгийн Засаг даргын 2019 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 1/441 тоот албан бичгээр бүх албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга нар үүрэг чиглэл өглөө. Уг албан бичгийн хавсралтаар дээрх тоглолтод оролцуулах ажилтан албан хаагчдын тоо, уртын дуу, морин хуурын сургалт явуулах сургагч багш нарын сургалтын хуваарь зэргийг хүргүүллээ.

2. "Уяхан замбуу тивийн наран" урлагийн их наадмыг зохион байгуулах комиссыг хуралдуулан, Их газрын чулууны байгалийн задгай театрт очиж газар дээр нь ажиллаа.
3. Засаг даргын зөвлөлийн 6 дугаар хурлаар "Аймгийн Засаг даргын нэрэмжит физикийн олимпиадыг зохион байгуулан, зардал гаргах тухай" асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.
4. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн албан даалгаварын 1 улирлын хэрэгжилт гарган ТЗУХ-т хүргүүллээ.
5. Цахим аюулгүй байдалтай холбоотой "Харуул занга -U18" тэмцээний талаар БСУГ болон аймгийн ерөнхий боловсролын сургуулиудад чиглэл хүргүүлэн ажиллалаа.
6. Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөлийг хуралдуулж, салбарын зөвлөлийн 2019 оны төлөвлөгөө, аймгийн дэд хөтөлбөрийн 2019 оны төлөвлөгөө, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны төлөвлөгөөг тус тус хэлэлцэн баталлаа.
7. Улсын хэмжээнд бүтээн байгуулалтын ажил эхэлж байгаатай холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр гарсан хууль эрх зүйн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажиллах талаар чиглэлийн сум, байгууллагын удирдлагуудад албан тоотоор хүргүүллээ.
8. Цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа цэргүүдэд жендэр ба жендэрийн эрх тэгш байдлын талаар 1 цагийн сургалт зохион байгууллаа.
9. "Уяхан замбуу тивийн наран" урлагийн их наадмын танилцуулга, брошурыг сум, албан байгууллага, ахуйн нэгжүүдэд хүргүүлэн сурталчилж байна.
10. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн дэд хөтөлбөрийн төслийг боловсруулан сум, байгууллага, иргэдээс төсөл дээр санал авч байна.
11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн сайн туршлагууд сэдэвт эмхэтгэлд Сайнцагаан сумын иргэн Нямсүрэнгийн Дашийн материалыг бэлтгэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт хүргүүллээ.
12. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөл олгох аймгийн салбар комисс хуралдаж Баянжаргалан, Өндөршил, Өлзийт, Луус, Адаацаг, Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумдын Эм эргэлтийн сангийн тусгай зөвшөөрлийн хугацааг 1 жилээр, "Тана шүдний эмнэлэг, "Сэтгэлийн жаргал" эмнэлэгийн тусгай зөвшөөрлийг 1 жилээр тус тус сунгах шийдвэрийг гаргалаа.
13. Аюулаас сэргийлэх цогцолбороор хүүхэд хамгаалал, БСШУСС-ын шинээр батласан тушаал, түүнийг хэрхэн хэрэгжүүлэн ажиллаж буй талаар иргэдэд мэдээлэл хүргэсэн.
14. Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны албаны төлөвлөгөөг Онцгой байдлын газраар хянуулж Засаг даргаар батлуулан ОБГ-т хүргүүллээ.
15. Аж ахуй нэгж, байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоосон Монгол улсын Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж ажиллах тухай албан тоотыг сум, байгууллагуудад хүргүүллээ.
16. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны нээлтийг "Эрүүл аюулгүй ирээдүйн хөдөлмөрийн төлөө" уриан дор зохион байгууллаа. Сарын аяны нээлтийн үйл ажиллагааны үеэр ХАБЭА талаар "Сайн туршлага" нэвтрүүлсэн албан байгууллагууд өөрсдийн танилцуулгаа хийж, Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын газар, Нэгдсэн эмнэлэг, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Мандалговь хүнс ХХК зэрэг 5 байгууллагыг Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөлөөс шилдэг санаа, тэргүүн туршлагатай байгууллагаар шалгаруулж Батламж гардууллаа.
17. Аймгийн "Нарны хүлэг" морин спорт уяачдын холбооны болон сумдын Засаг дарга нарын саналыг үндэслэн 2019 онд зохион байгуулах аймгийн хурдан морины бүсийн уралдааны хуваарийг аймгийн Засаг даргын 2019 оны А/163 тоот захирамжаар батлан гаргалаа.

18. ХХ зууны Төр нийгмийн зүтгэлтэн, Морьт отрядын жанжин, Хошууч генерал, Монгол Улсын заан Чимэдийн Мижидийн Монгол Улсын заан цолонд хүндэтгэл үзүүлэх улс, аймгийн алдар цолтой хүчит бөхийн барилдаан болохтой холбогдуулан улсын цолтой аймгийн уугуул 6 бөхөд хүндэтгэл үзүүлэх, Волейболын спортын Олон улсын хэмжээний мастер Монхорын Гаамаагийн нэрэмжит “Дундговь сайхан нутаг-2019” волейболын нээлттэй тэмцээний үйл ажиллагаанд тус бүр 1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлүүлэлээ.

19. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн салбар зөвлөл хуралдаж, 2019 онд малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх сумд, ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэх сумдыг тус тус шалгаруулж, салбар зөвлөлийн 2019 онд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталлаа.

20. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр Засгийн газрын цахим хурал зохион байгуулагдлаа.

21. БСУГ-т Зүүн Хойд Азийн нутгийн захиргаандын холбооноос зохион байгуулагддаг гар зураг, посперын уралдаанд оролцох уралдааны удирдамж хүргүүлээ.

#### **Боловсролын чиглэлээр:**

1. Аймгийн төрөлжсөн олимпиадын химийн хичээлийн олимпиад зохион байгуулагдлаа.

2. Багш нарын 7-р хуралд оролцох багш нарын мэдээллийг БСШУСЯ-нд хүргэж ажиллалаа.

3. Туслах багш нарын мэргэжил дээшлүүлэх 3 кредитийн сургалтыг багшийн мэргэжил дээшлүүлэх институтын дэргэдэх “Сэтгэлийн оньс” төвтэй хамтран Дундговь аймгийн СӨБ-ийн мэргэжилтэн Ц.Отгонжаргал зохион байгуулан, тус сургалтад 19 цэцэрлэгийн 68 туслах багш хамрагдаж байна.

4. ЕБСургуулийн мэргэжлийн багш нар 5, 9, 12 дугаар ангийн сурагчдаас авсан түвшин тогтоох шалгалтын материалуудыг засан дүнг нэгтгэлээ.

5. Аймгийн төрөлжсөн олимпиадын физик, сэтгэх чадвар, мэдээлэл зүйн төрөл зохион байгуулагдаж төрөлжсөн олимпиад дууслаа.

6. Боловсролын чанарын шинэчлэл төслөөс бага ангийн номын санд зориулан хэвлэсэн, 11638 ширхэг номын мэдээллийг Боловсролын мэдээллийн системд нэмлээ.

7. Англи хэлний ментор зөвлөх багшийн сургалтад БСУГ-ын англи хэлний мэргэжилтэн хамрагдлаа.

8. "Ногоон паспорт эзэмшигч багш сурагчдын" уулзалт ОУХ-ийн Найрамдал төвд болж БОАЖГ, БСУГ-ын мэргэжилтнүүд хамтран оролцлоо.

9. Элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэлд 150 хүүхэд хамрагдаад байна.

10. Мандал сургуулийн залуу багш нарын ур чадварын уралдааныг зохион байгуулж БСУГ-ын мэргэжилтэнгүүд шүүгчээр ажиллаж байна.

11. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг олон талт хамтын ажиллагаа үндэсний III чуулган Улаанбаатар хотноо 18-19-нд зохион байгуулагдаж БСУГ-ын дарга оролцлоо.

12. Аймгийн аварга шалгаруулах мэтгэлцээний тэмцээнийг 9-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулж 6 сургуулийн 11 баг оролцож, тэмцээнийг Монголын мэтгэлцээний нийгэмлэгийн шүүгчид шүүж явууллаа.

13. Монгол хэлний улсын массын олимпиадыг 9 дүгээр ангийн 632 хүүхдэд зохион байгууллаа.

14. Үндэсний бичиг үсгийн баярын үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулагдах Бийрийн бичлэгийн уралдааны удирдамжийг батлуулан байгууллагуудад хүргүүлж ажиллалаа.

15. МУГБагш  
3.Цэвээнравдангийн нэрэмжит Монгол хэлний улсын массын олимпиадыг 9-р ангийн 632 хүүхдэд зохион байгууллаа.
16. Үндэсний бичиг үсгийн баярыг Эрдмийн далай цогцолбор сургууль дээр 6-12 дугаар ангийн сурагчид, төрийн албан хаагчид, насанд хүрэгчдийн дунд зохион байгуулагдах МОНГОЛ БИЧГИЙН АНГИ НИЙТИЙН ОЛИМПИАД-ыг 1723 сурагчдыг 4 бүс болгож зохион байгуулалаа.
17. 1-р цэцэрлэгийн барилгын хүчин чадал нэмэгдэхтэй холбоотойгоор Сайнцагаан сумын сургууль, цэцэрлэгийн хамран сургах тойргийг тогтоох ажлын хэсгийг томилон ажиллуулж байна.
18. Элсэлтийн ерөнхий шалгалтыг 2019 онд шууд засалттай зохион байгуулах сургалтыг БСУГ-ын мэргэжилтнүүдэд Боловсролын үнэлгээний төвөөс техник хариуцсан багш, БҮТ-ийн мэргэжилтэн зохион байгуулав.
19. Монгол хэл бичгийн 400 онооны шалгалтад 21 хүүхэд бүртгэгдснээс 18 шалгуулагч шалгалтад орсон.
20. Дундговь Зөн Олон улсын байгууллага өөрийн эзэмшлийн байр, 17 нэр төрлийн тавилга, тоног төхөөрөмжийг БСУГ-т хандиваар хүлээлгэн өглөө.
21. 3000 морин хуурч уртын дуучдын сургалтад ТТХТ-т 123 хүн хамрагдахаас 41, ТХДЖТ-т морин хуурын сургалтад 102 хүн хамрагдахаас 60, уртын дууны сургалтад 180 хүн хамрагдахаас 66 хүн огт хамрагдаагүй байна.
22. Сайнцагаан сумын сургуулиудын 6-р ангийн сурагчдын дунд компьютер дээр хурдан бичих уралдааныг багаар зохион байгуулж ажиллалаа.
23. 1-р ангийн сурагчдын унших чадварын материалыг боловсруулж сургуулиудад хүргэж ажиллалаа.

### **Эрүүл мэндийн чиглэлээр:**

1. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 255 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийн нээлтийг 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр хийлээ. “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийг 2019-2023 онд 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэх бөгөөд хүүхдийн шүдний тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүжилтын тогтвортой байдлыг хангаж, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар 2023 он гэхэд хүүхдийн шүдний өвчний тархалтыг 30 хувиар цоорлын эрчмийг 4 нэгжээр бууруулахаар зорьж байна.
2. Эрүүл мэндийн газраас харъяа эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд “Авто ослоор алаг үрсээ алдсаар байх уу” уриан дор өдөрлөг зохион байгуулах талаар ажлын чиглэл өгч, аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасагтай хамтран 2019 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 12:30-13:00 цагийн хооронд “АВТО ОСЛООР АЛАГ ҮРСЭЭ АЛДСААР БАЙХ УУ” уриан дор нэгдсэн өдөрлөгийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Өдөрлөгийн үйл ажиллагааны нээлтийг “Мандал” худалдааны төвийн талбайд хийж, аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн албаны дуут дохиот автомашинуудад өдөрлөгийн уриаг байршуулан нийт эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн ажилтнууд “АВТО ОСЛООР АЛАГ ҮРСЭЭ АЛДСААР БАЙХ УУ” уриаг зам тээврийн аюулгүй байдлыг хангах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх санамж зөвлөмжүүдийг барьж аймгийн төвийн зам дагуу жагсаал хийж иргэдэд уриалга гаргалаа. Мөн аймгийн Эрүүл мэндийн газраас эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийг ажиллах цэгүүдийн байршлыг хуваарилан гаргаж, эрүүл мэндийн байгууллагууд хуваарилагдсан цэгүүддээ уриа, лоозон барьж “Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлье” сэдвийн хүрээнд гарын авлага, зөвлөмж, санамжуудыг хэвлүүлэн гаргаж иргэд, жолооч нарт сурталчилгаа хийж

ажиллалаа.

Өдөрлөгийн үйл ажиллагаанд аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төв, Уламжлалт анагаах ухааны төв, Сайнцагаан сум, Боржигонмандал, Өлзийтмандал өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчид болон Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн албан хаагчид нийт 152 хүн оролцож ажиллалаа.

Эрүүл мэндийн газрын ажилчид аймгийн постоор орж гарч байгаа автомашинуудад зөвлөмж өгч ажиллалаа.

3. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах, ёс зүйн алдаанаас урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан Эрүүл мэндийн сайд 2019 оны 1 сарын өдрийн “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сургалт зохион байгуулах тухай” А/19 дүгээр тушаал батлагдсан гарсан. Тушаалын дагуу ёс зүйн сургалтыг бүх шатны эрүүл мэндийн байгууллага нь ёс зүйн сургалтыг сар бүр зохион байгуулах үүрэгтэй. Эмнэлгийн эрх зүй ба ёс зүй, анагаах ухааны эрх зүй, хууль эрх зүйн хариуцлага сэдвээр Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны гишүүн хуульч, эмч М.Цэрэнбат 2019 оны 4 дүгээр сарын 9-ны өдөр сургалт зохион байгуулж сургалтанд төв хөдөөгийн нийт 50 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд болон аймгийн эрүүл мэндийн газрын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны гишүүд, ёс зүйн багийн гишүүд хамрагдлаа.

4. Өсвөр үеийн эрүүл мэндийг хамгаалах 7 хоногийн ажлын хүрээнд Мэргэжил сургалт үйлдэрлэлийн төвийн 107 сурагчдад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж сургалт хийлээ.

5. “Хачгаар дамжих халдварын оношилгоо, урьдчилан сэргийлэлт” сэдэвт ОУ-ын уулзалт зөвлөгөөн Сэлэнгэ аймагт зохион байгуулагдаж Нэгдсэн эмнэлгийн халдвартын их эмч, Зооноз өвчин судлалын эмч нар хамрагдлаа.

6. Ахмад настануудын эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн мэдээлэл сурталчилгааг өргөжүүлэх зорилгоор Лхагва гараг бүрт ахмадуудад эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа, арга хэмжээг зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд 4 сарын 10-нд Нэгдсэн эмнэлгийн удирдлагууд Сайнцагаан сумын ахмадуудтай уулзалт зохион байгуулж, Нэгдсэн эмнэлгийн 2018 оны үйл ажиллагааны тайлан, цахим цаг товлолт үйлчилгээ, хүлээгдлийг хэрхэн тооцож бууруулж буй талаар, цаашид хийгдэх үйл ажиллагааны чиглэлийн талаар мэдээлэл хийж, ахмадуудын санал, хүсэлтэнд хариуллаа.

7. Дэлхийн Эрүүл Мэндийн өдрийг тохиолдуулан Үйл оношийн тасаг “Элгээ хамгаалъя” уриан дор нээлттэй мэдээллийн өдөрлөгийг зохион байгуулж, уг арга хэмжээнд 170 үйлчлүүлэгч, эмч эмнэлгийн ажилтнуудад мэдээлэл өгч, “Элэгний хорт хавдрын эрт үеийн оношлогоо” гарын авлагыг 200 үйлчлүүлэгчдэд тарааж, зөвлөмж өглөө.

8. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд сувилагчийн оролцоо нээлттэй мэдээллийн өдөрлөгийг зохион байгуулж “Чимээгүй үхэл таригч ундны усны сав” сэдэвт сургалтыг 80 иргэнд, үйлчлүүлэгч, эмч, эмнэлгийн ажилтнуудыг оролцуулан зохион байгууллаа.

9. Нэгдсэн эмнэлэг Эрүүл мэндийн сайдын 2018 оны 02-р албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор 230 эмнэлгийн эмч, ажилтнуудад 8,7 сая төгрөгийн ажлын дулаан хувцсаар хангалаа.

10. Аймгийн Нэгдсэн эмнэлгээс Жирэмсэн хяналтын үзлэгийг чанаржуулах, сэтгэлзүйн хямрал, айдас, түгшүүр, сэтгэл гутрал, гэр бүлийн хүчирхийлэл зэргийг эрт хугацаанд илрүүлэх, шаардлагатай тохиолдолд холбон зуучлаж ажиллах зорилгоор “Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед сэтгэлзүйн хямралд орохоос урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалт, зөвлөмж, мэдээллийг 40 гаруй эмэгтэйчүүдэд өглөө.

**ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**



Улсын тариаланчдын зөвлөгөөнд Дундговь аймгийн ХХААГ, сумдын ХАА-н тасгийн мэргэжилтэн, тэргүүний тариаланч 8 хүн оролцлоо

МЭЕГ болон НҮБ-ын ХХААБ хамтран хэрэгжүүлж буй TCP/MON/3701 төслийн хүрээнд "Халдварт өвчний дэгдэлтийн судалгаа" сэдэвт сургалтанд 15 сумын мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүд хамрагдлаа.

Ургамал хамгаалалын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дарга Ц.Бямбасүрэнгээр ахлуулсан эрдэмтдийн баг манай аймгийн бэлчээрт хөнөөл учруулж буй үлийн цагаан оготоны тандалт хийж ХХААХҮЯамнаас үлийн цагаан оготныг устгахаар 21 аймагт тус бүр 40тн будаа хуваарилагдснаар Аймгийн Засаг даргын 2019 оны 04 сарын 22 өдрийн А/156 тоот захирамжийн дагуу 10 суманд 20,0 мян.га бэлчээрийн талбайд микробиологийн аргаар тэмцэх арга хэмжээг зохион байгуулж байна.

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн санаачлагаар Улаанбаатар хот дахь Жавзандамба хутагт төв ТББ-аас жил бүр өрнүүлдэг "Монгол хүн монгол хүнээ хайрлая" уриатай сайн үйлсийн аяныг хамтран зохион байгууллаа. Бусдын тусыг бусдад түгээх эрхэм зорилготой мал цөөтэй амьдралын түвшин доогуур малчин өрхөд туслаж ирсэн тус аян нь жил бүр нэг аймгийг сонгон хүмүүнлэгийн тусламж хүргэдэг. 3 дахь жилийн аяны хүрээнд манай аймаг сонгогдсноос Дэлгэрхангай, Луус, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Дэлгэрцогт сумдын 50 малчин өрх тус бүр 250,000 төгрөгийн өвс тэжээл, хүнс, хувцас, Сайнцагаан сумын амьдралын түвшин доогуур нэн ядуу өрхөд хувцас, хүүхдийн тоглоом, хичээлийн хэрэглэлийн тусламжуудыг үзүүлээ. Тусламжид өгсөн өвс, тэжээл, гурил, будаа, ургамлын тос, чихэр зэргийг орон нутгаас худалдаж авч байгаа нь малчдад төдийгүй аж ахуйн нэгж байгууллагуудад дэмжлэг боллоо.

Мөн Дэлгэрхангай сумын малчин Ц.Ганбатын өвөлжөөнд гал түймэр гарсны улмаас 4,5 ханатай 3 гэр, 4 жижиг байшин буюу амбаар, PRIUS 20 маркын автомашин, журд мотоцикль, гэрийн эд хогшил зэрэг нь галын аюулд өртөж шатсныг газар дээр очиж үзээд 1,0 сая төгрөгийн хандивыг тус малчинд хүргэлээ.

#### **Жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний чиглэлээр:**

ХХААГ, Эрүүл мэндийн газар, Стандарт хэмжил зүйн газар, Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газар, Дундговь аймаг дахь Монголын тогооч нарын холбооны салбар байгууллагууд хамтран "Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье" жилийн ажлын хүрээнд хүнс үйлдвэрлэгчид, төсөвт байгууллагын удирдлага, тогооч 50 гаруй хүнийг хамруулан сургалт зохион байгууллаа. Уг сургалтаар Монголын тогооч нарын холбооны тэргүүн доктор профессор С.Нарангэрэл "Давсны хэрэглээг бууруулах стратеги", "Давсыг хэрхэн зөв зохистой хэрэглэж хэвших", "Хоолны технологийн карт хөтлөлт, шимт бодис илчлэгийг хэрхэн тооцох" талаар мэдлэг олгосноор давсны агууламжийг бууруулах төрөл бүрийн зөвлөгөө, мэдээлэл авч, шинэ жор, технологид суралцсан үр дүнтэй ажил болжээ.

Хэрэглэгчдийн 230 ш цахилгааны тоолуур, худалдаа үйлчилгээний 40 газар, ШТС-ын 31 түгээгүүр, ААН, байгууллагын 25 жинг стандартын дагуу тус тус баталгаажуулан гэрчилгээжүүлсэн байна.

#### **ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

##### **Байгаль орчны аялал жуулчлал, ашигт малтмал уул уурхайн чиглэлээр:**

Канад улсын MERIT төслийн хүрээнд Дорнод их сургуулийн багш нартай хамтран "Уул уурхайн амьдарлын мөчлөг" сэдэвт 6 өдрийн сургалтыг Хулд, Гурвансайхан, Баянжаргалан сумдын нийт 105 иргэд, албан хаагчдад зохион байгууллаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Хэнтий аймагт зохион байгуулсан "Биологийн олон янз байдал, био аюулгүй байдал" сэдэвт зүүн бүсийн сургалт мөн Нээлттэй нийгэм форумас хамтран зохион байгуулсан "Алтны бичил уурхайгаас үүдэлтэй бохирдлыг бууруулах үндэсний төлөвлөгөө /хөтөлбөр/"-ийн төслийн эцсийн хувилбарыг хэлэлцэх,

“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох” журам болон холбогдох хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах хэлэлцүүлэгт холбогдох мэргэжилтэн, албан хаагчидтай оролцлоо.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 4-р сарын 22-23-ны өдөр зохион байгуулах “Гэрээний мэдээллийн сангийн нээлт, Цахим сангийн сургалт, орон нутгийн гэрээний зохицуулалт, хэрэгжилт, үр нөлөө” сэдэвт сургалт, семинар, хэлэлцүүлэгт Хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтэн оролцсон байна.

Баянжаргалан сумын нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй “Монгоулд” ХХК-ний 2018 оны хайгуулын ажлын тайланг хүлээн авч, 2019 оны хайгуулын ажлын төлөвлөгөөг хүлээн авав.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй Баянжаргалан суман дахь “Монгоулд” ХХК, Гурвансайхан суман дахь “Эрдэнэс трак” ХХК, Цагаандэлгэр сумын нутаг дэвсгэрт хайгуулын тусгай зөвшөөрөлтэй “Сүмбэр-орд” ХХК-ний хайгуулын ажлын байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хянан бүртгэж сумдад нь хүргүүлэв.

Цагаандэлгэр сумын нутаг дэвсгэрт хайгуулын тусгай зөвшөөрөлтэй “Сүмбэр орд” ХХК-д унд ахуйн болон хайгуулын өрөмдлөг, Өлзийт сумын нутагт ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Мэжик бридж” ХХК-д унд ахуйн болон зам талбайн тоосжилт дарахад ашиглах ус ашиглуулах дүгнэлт гаргав.

Хэлтсийн уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн, Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга Т.Розон, Эргүүлийн цагдаа О.Бүрэнбат, Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч П.Нямсүрэн нарын хамт Эрдэнэдалай, Хулд, Өлзийт, Өндөршил, Баянжаргалан, Говь-Угтаал зэрэг сумдын уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн гэрээт харуул хамгаалалт, тэсрэх бодис, тэсэлгээний материалын агуулахын байдлыг үзэж шалгалаа.

2019 оны 4 дүгээр сарын 6-11-ний өдөр Олон улсын найрамдал зусланд “Ногоон паспорт эзэмшигч шилдэг багш, сурагчид” арга хэмжээнд “Нийлэг хальсан уутнаас татгалзья видео уралдаан”-д шалгарсан Дундговь аймгийн Цэгцбилэг сургуулийн 7 сурагч, биологийн багш, Боловсрол соёл, урлагийн газрын мэргэжилтэн, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн нийт 10 хүн оролцлоо.

БНСУ-ын Засгийн газраас санхүүжүүлдэг “Монгол-Солонгос”-ын “Ногоон хэрэм” хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэх эсэхийг газар дээр нь судалж баримтат кино хийхээр Солонгосын ВВС телевизийн найруулагч, зураглаачид Сайнцагаан сумын 3 дугаар багийн далайн “Хүрэн тойром”, “Хувийн булаг” –ийн хатаж ширгэсэн байдлыг зураглаж, нутгийн иргэдээс ярилцлага авч нэвтрүүлэг бэлтгэлээ.

Агаар дахь хүхэрлэг хийн агууламж 0,009 мг/м<sup>3</sup> байгаа нь агаарын чанарын стандарт MNS 4585:2007 хүлцэх агууламжаас 50 дахин бага байна. Азотын давхар исэл 0.026 мг/м<sup>3</sup> байгаа нь хүлцэх агууламжаас 7 дахин бага байна. Агаарын чанарын шинжилгээний бодис урвалжийг найруулж бэлтгэсэн.

ОХУ-ын Улаан-Үдэ хотод Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн оролцон Дундговь аймгийн талаар, 3000 уртын дууч, морин хуурчдын арга хэмжээ, Хотод ойрхон говь эвент арга хэмжээ зэргийг сурталчлан ажиллав.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Эрээн хотод мод тарих, суулгац бэлтгэх сургалтанд Сум дундын ойн ангийн дарга оролцон туршлага солилцлоо.

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “БАЙГАЛИА ХАМГААЛЪЯ” нэгдсэн арга хэмжээний өдөрлөгийг 2019.04.23-ны өдөр холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Арга хэмжээнд оролцсон төрийн албан хаагчид, иргэд олон нийтэд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, мэргэжлийн байгууллагуудын хамтын үйл ажиллагаа, цаашид авах арга хэмжээний талаар мэдээлэл хийж, байгууллагын гарын авлагыг тарааж ажиллалаа.

2019 оны 4 сарын 26-ны өдөр Новотел Улаанбаатар зочид буудалд зохион байгуулж буй “Зочлох үйлчлэх салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээ”-ний сургалтанд тус аймгийн 2 зочид буудал, 2 жуулчны баазын нийт 5 хүн хамрууллаа.

#### **Дэд бүтцийн чиглэлээр:**

Орон нутгийн дулааны эрчим хүчний хэмнэлт ашиглалтыг дээшлүүлэх сургалт зөвлөгөөнд эрчим хүчний зохицуулах хорооны гишүүн, 5 галлагааны компанийн инженерүүд оролцон хууль дүрэм, бодлого төлөвлөлт ашиглалт горимийн тооцоо засвар үйлчилгээ аймгуудын туршлагын талаар ярилцлаа.

ГХБХБГ-ын дарга, газрын үнэлгээ, татвар, төлбөр хариуцсан мэргэжилтэн нар 2019.04.22-2019.04.28-ны хооронд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт холбогдох чиглэлийн дагуу сургалтад хамрагдлаа.

Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус аймагт хэрэгжүүлэх 8 арга хэмжээг тусгуулахаар саналыг Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газарт хүргүүллээ.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй Дэлгэрхангай сумын 320 суудалтай сургууль, спорт заалны барилга, Эрдэнэдалай суманд баригдаж байгаа 22 ортой эмнэлгийн барилга, Баянжаргалан сумын 100 ортой цэцэрлэгийн барилга, Сайнцагаан сумын 100 ортой цэцэрлэгийн барилга, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ний Говийн бүсийн салбарын оффисын барилга угсралтын ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэлээ.

### **ДОЛОО. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭР**

#### **НАЙМ. СУМ, ОРОН НУТГИЙН ТАЛААР**

**Адаацаг сум:** Дорноговь, Төв, Дундговь аймгийн захиргаа, дотоод ажил эрхзүй хариуцсан албан хаагчид Удирдлагын академийн Мэргэжил дээшлүүлэх институт дээр “Нутгийн захиргааны байгууллагын дотоод ажил зохицуулалт” сэдэвт сургалтанд хамрагдан сертификат гардан авсан. Нийт 52 хүн хамрагдсан.

ЗДТГ-ын албан хаагч нарт төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёсзүйн дүрмийн талаар сургалтыг зохион байгуулж албан хаагч нартай ёсзүйн гэрээ байгуулсан.Сургалтанд нийт 14 албан хаагч хамрагдсан.

Төрийн захиргааны албан хаагч нарт Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргазүйн сургалтыг зохион байгуулсан бөгөөд нийт 9 албан хаагч хамрагдсан.

Энэ сард Мэдээллийн цаг” хөтөлбөрийг 3 удаа зохион байгуулсан бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн талаар, Замын хөдөлгөөний шинэчилсэн дүрмийн талаар, Нийгмийн даатгалын хүрээнд 2019 онд шинээр батлагдан гарсан хууль дүрмийн талаар иргэдэд мэдээллийг өгсөн бөгөөд энэ үеэр төрийн байгууллагууд “Нэг хором” аянд нэгдсэн.Нийт 143 иргэн хамрагдсан.

Сумын эрхзүйн хөтөч багийг 2019.04.01-ны А/49 тоот захирамжаар шинэчлэн нийт 12 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан хурлаа хийж эрхзүйн хөтөч багийн 2019 онд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталлаа.

**Баянжаргалан сум: “МАЛЧНЫ ХОТОНД” 1 ӨДРИЙН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.**

Тус сумын 2-р багийн мянгат малчин, сумын алдарт уяач Ц.Уртнасангийнд очиж нэг өдрийн ажилд нь хамт олноороо тусаллаа. Төлийн дуу цангинаж, ноос ноолуурын үе эхэлсэн хүн хүчний мөрөөсөл болсон энэ үед цагаа олсон ажил байлаа хэмээн гэрийн эзэгтэй хүлээн

авлаа. Бид хийх ажлаа хуваарьлан тус тусынхаа ажилд шамдан нэгэн өдрийг өвөг дээдсээс уламжлан ирсэн нүүдэлчин монголын удмыг залгуулж яваа малчны хотонд өнгөрөөлөө. “Хоггүй Баянжаргалан” аяны хүрээнд Засаг даргын захирамж гарч сумын төвийн нийтийн хог цэвэрлэгээнд 153 гаруй иргэн, 1 ковш, 8 автомашин 2 өдөр ажиллаж 0.2 га газрыг шууз, 1 га газрыг цэвэрлэсэн.

**Говь-Угтаал сум:** Сумын хөгжилд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, хүрээлэн буй орчиндоо амар амгалан, эрч хүч, эв нэгдэл, үлгэр дууриалалтай манлайлан ажиллаж амьдрах сэтгэлзүйг бий болгох, орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор “АЗ ЖАРГАЛТАЙ ГОВЬ-УГТААЛ” хөтөлбөрийг санаачлан 2019.04.08-ны өдөр Залуучуудын дунд хэлэлцүүлэг уулзалт зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт залуучууд маань үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж дугуйн клуб байгуулах, мини кино театртэй болох, архины хэрэглээнээс татгалзая, аливаа арга хэмжээнд цаг барьж оролцох зэрэг олон шинэ санал, санаачилга гарсан уулзалт боллоо. Мөн 2019.04.15-ны 7 цагаас эхлэн Төв талбай дээр 16 тоот дасгал хийж эхлэхээр, түүнийг хэвшил болгоход залуучууд санаачлагатай ажиллахаар болсон. “АЗ ЖАРГАЛТАЙ ГОВЬ-УГТААЛ” хөтөлбөрийг боловсруулан батлуулж албан ёсоор олон нийтэд зарлах болно. Залуучуудын холбооны үйл ажиллагааг тасралтгүй явуулах, идэвхжүүлэх зорилгоор 2018 оны Залуучуудын чуулга уулзалтаар сонгогдсон тэргүүлэгчдийн бүрэлдэхүүн дээр нэмж албан байгууллагуудаас төлөөлөл оруулах нь зүйтэй гэж үзэн Г.Пүрэвдаш, Ц.Батцэцэг, Х.Отгончимэг, Т.Шуухааз, М.Оюунтүлхүүр, Ч.Эрдэнэтогтох нарыг тэргүүлэгчээр томиллоо. “АЗ ЖАРГАЛТАЙ ГОВЬ-УГТААЛ” хэлэлцүүлэгээр дараах 2 уриалгыг гаргалаа. Үүнд:

1. Аливаа арга хэмжээг яг цагтаа эхлүүлж байх. Цагтаа эхлээгүй алдсан сул цагийг дуусах цагаас нь хасаж тооцдог болох. “Яг цагтаа Бид цугтаа”
2. Олон нийт арга хэмжээнд үзэгчийн байрнаас биш Оролцогчийн байрнаас манлайлья залуусаа

**Дэлгэрхангай сум:** 1. Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны нэгдсэн төлөвлөгөөний дагуу Батцагаан хаан ХХК, Толийн-Ундарга ХХК-иудад, Засаг даргын Тамгын газрын барилга, шинээр баригдаж байгаа сургуулийн барилга, Соёлын төв, ЭМТөв, Хүүхдийн цэцэрлэгийн барилгууд, гудамж талбайд барилгын техникийн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 4 дүгээр сарын 4-ны өдөр хийлээ. Мөн ашиглагдахгүй байгаа барилгуудад улсын байцаагчийн дүгнэлт гаргууллаа. Мэргэжлийн хяналтын хүнсний үйлдвэрлэл, худалдаа, нийтийн хоолны хяналтын улсын байцаагч Н.Болормаа “Хүнсний нэмэлт” сургалтыг хийлээ. Сургалтанд ААН-ийн захирал, худалдаа үйлчилгээний ажилтнууд, төрийн албан хаагч иргэд хамрагдлаа.

2. 2019 оны 4 сарын 4-5-ны өдрүүдэд Дундговь аймгийн ШШГГАзраас ШШГүйцэтгэгч Отгонжаргал ирж шүүхээс ирсэн захирамжийн дагуу 6 иргэнтэй биечлэн уулзаж үндсэн зээл, зээлийн хүү, алданги зэрэг мөнгөн төлбөрийг төлүүлэх ажлыг шуурхай зохион байгууллаа.

3. Тус сумын Багийн Засаг дарга нар, Төрийн сангийн мэргэжилтнүүд хамтран 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн 2019 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийг хүртэлх хугацаанд ХАӨМС-нд бүртгэлтэй нийт иргэдийн 20 хувийг баг тус бүрээр үзэж хувийн мэдээллийн шинэчлэл, өрхийн үзүүлэлтүүдийг шалгалаа. Толь багийн хувьд 130 иргэний хувийн мэдээлэл, Таргат багийн хувьд 106 иргэний хувийн мэдээлэл, Шавагтай багийн хувьд 120 иргэний хувийн мэдээлэл, Номгон багийн хувьд 553 иргэний хувийн мэдээллийг үзэж тус тус тулгалт хийсэн. Толь,Таргат, Шавагтай багуудын хувьд сонгосон иргэдийн мэдээллийн тулгалт амжилттай хийгдэж алдаагүй болохыг хянаж үзлээ. Номгон багийн хувьд 300 гаруй иргэдийн мэдээллийг засварласан. ХАӨМС-н программны хувьд дутагдалтай зүйл одоогоор байхгүй. Дээрх хугацаанд Багийн Засаг дарга нартайгаа хамтарч мэдээллийн сангийн баяжилтыг сайтар анхаарч ажиллалаа.

**Дэлгэрцогт сум:** Сумын Засаг даргын 2019 оны А/24 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг 4-р сарын 1-2-ны өдрүүдэд Авто техникийн улсын үзлэгийг зохион байгуулж, үзлэгт 188 авто машин, 65 мотоцикль хамрагдлаа.

Сумын төв дээр мал малтай байгаа мал бүхий иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгууллаа. Дэлгэр–Эмт багийн Бэлчээр ашиглагч малчдын “Тоонот” нэртэй байгуулагдсан бүлэг зохион байгуулалтын хурлаа хийсэн. Хурлаар бүлгийнхээ нэрийг “Алаг” болгон сольж, бүлгийн ахлагчаар Ц.Нямсүрэнг сонголоо. Хяналтын зөвлөлөө сонгож, бүлгийн дүрэм, дундын сангийн журам, ажлын төлөвлөгөөгөө хэлэлцэн батлав. Хуралдаанд 26 өрхийн төлөөлөл 19 хүн оролцож, 73,1%-ийн ирцтэй хуралдлаа. ЭДБ-ээс “Цахирын цагаан алт”, “Амардалай” бүлгийн ахлагч нар бизнес төлөвлөгөө хийх талаар зөвлөгөө авлаа. “Ногоон сувд” бүлгийн ногоочин Ч.Доржпүрэв тариаланчдын улсын зөвөлгөөнд оролцож байна. Бэлчээрийн удирдлагын бүрэлдхүүн хэсгийн ажилтан Ч.Ганчимэг мотоциклоо хүлээн авлаа.

**Дэрэн сум:** Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн гуравдугаар хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэр гарган ажилласан.

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах
2. Сум хөгжүүлэх сангийн төсвийг баталж, сангаас тухайн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох
3. Сум хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэл батлах
4. ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах
5. Хамтарсан багийн 2019 онд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
6. Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах зэрэг асуудлуудыг хэлэлцэн батлав.

Мөн “Алаг өндөр” багийн Иргэдийн нийтийн хурлаас Монгол бахархал-2019 арга хэмжээг зохион байгуулан ажилласан.

МАННА ТББ нь манай сумын 4-р багийн залуу гэр бүл Түвшингэрэлийн амьдарлыг дэмжиж өргөө цагаан гэр бэлэглэлээ.

ОНХС-ийн сумын ажлын хэсэг ОНХС-ийн шинээр батлагдсан журам, Хөдөлмөр, халамж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн талаар иргэд, ТАХ-чид нарт сургалт зохион байгуулсан.

ГХУССЗ-өөс 2019 онд гарсан гэмт хэрэг зөрлийн талаар танилцуулга хийн сэрэмжлүүлгийн хүргэсэн.

Улсын бүртгэлийн тухай багц хуулийн шинэчилсэн найруулга, Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг танилцуулан хог хаягдлын төлбөр хураамжийн талаарх хэлэлцүүлгийг иргэд, төрийн албан хаагч нарт явуулсан.

Саруул, Долоод, Бумбат багууд БЗД, багийн эмч, ХАА-н мэргэжилтэн, малын эмч, НД-ын байаагчийн бүрэлдэхүүнтэйгээр хөдөөгийн малчин өрхөөр тойролт хийсэн. Нийт 150 гаруй өрхөөр орж төрийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажилласан. Тойролтоор:

- Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын санал асуулга
- Эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээ
- Цэргийн зарлан дуудах хуудас тараах
- 6 наснтай 9-р сард сургуульд орох сургуулийн насны сурагчдын урилга тараах
- Бусад цаг үеийн асуудлыг танилцуулан ажилласан.

Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2019 оны 1 дүгээр улиралд хийсэн ажлын тайлан, 2 дугаар улирлын ажлын төлөвлөгөөг хэлэлцэн

батлав. Мөн Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлыг эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 1 хором хөдөлгөөнд албан байгууллага, аж ахуй нэгжүүд нэгдлээ.

2019 оны хаврын ээлжит цэрэг татлага 4-р сарын 14-нд суманд зохион байгуулагдаж 60 гаруй залуучууд комисст хамрагдаж 12 цэрэг тэнцлээ. Сумын өндөр настан Х.Сэрээ, Цэрэнханд нар олон хүүхэд төрүүлж өсгөж 9 хүү цэргийн албанд мордуулсан гавьяаг үнэлэн аймгийн Цэргийн штабаас хүндэтгэл үзүүлж өргөмжлөл дурсгав.

Аймгийн хууль, эрх зүйн хэлтэс, Оюуны гэгээ” ТББ-ууд хамтран Дэрэн сумын ЗДТГ, ЕБС-ийн ажилтан албан хаагчид, сургуулийн сурагчдад:

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Харилцаа зэрэг сэдвүүдээр төрийн албан хаагч нарт сургалт зохион байгуулсан. Мөн сумын ЗДТГ-ын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаатай танилцсан. Цэгц билэг” сургуулийн нийгмийн ажилтан ЕБС-ийн 5-9р ангийн сурагчдын төлөөлөл нарт “Оролцооны арга” сургалтыг зохион байгуулсан.

ЗДТГ-ын дарга Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан батлагдан гарсан ЗГ-ын тогтоол, дүрэм, журмууд, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний талаарх танилцуулга, сургалтыг ЗДТГ-ын мэргэжилтнүүд, байгууллагын дарга, эрхлэгч нарт зохион байгуулсан.

**Луус сум:** ЗДТГ-ын албан хаагчдад Тамгын газрын дарга Төрийн албаны тухай хууль, дагаж гарсан журмууд, Төрийн албаны шинэчлэл, Албан хэрэг хөтлөлтөд анхаарах асуудлуудаар, Улсын бүртгэгч Улсын бүртгэлийн багц хууль, Иргэний Улсын бүртгэлийн тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиудаар сургалт зохион байгуулаа. Албан хаагчдын Албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлыг ажлын асуулгын аргыг хэрэглэн шинжилгээ хийж сургалт зохион байгуулаа. Албан хаагчдын Албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлыг ажлын асуулгын аргыг хэрэглэн шинжилгээ хийж ЗДТГ-ын албан хаагчдад хуулиудаар сургалт явууллаа. Монголын Лекторуудын холбооны гишүүн “Удирдлага Шинэчлэлийн Академи”-ийн сургагч багш доктор Б.Гансүх хувь хүний хөгжил сэдвээр төрийн албан хаагчдад сургалт явуулж 50 орчим ТАХ-д хамрагдлаа. “Жавзандамба хутагт” ТББ-аас цөөн малтай, өрхийн амьжиргаа доогуур малчдад тусламж үзүүлэх ажлын хүрээнд 10 өрхөд тусламжийн бараа гардуулж өгөх үйл ажиллагаа явагдлаа

**Өлзийт сум:** Төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” тэтгэлэгт хөтөлбөрт “Чадавхтай хороо-Иргэний төлөөлөл” төсөл боловсруулж хүргүүлсэн. ИТХ-ын ээлжит 8-р хуралдааныг 4 дүгээр сарын 18-нд хийж 6 асуудал хэлэлцэн шийдвэрлэлээ. Өлзийт сумаар дайран өнгөрөх замын хариуцагч компани удирдлагуудаар замын маршрут, гарч болох сөрөг үр дагаврууд, тэдгээрийг арилгах талаар мэдээллийг төлөөлөгчдөд танилцуулж асуултанд хариулав. Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын газрын 2019.03.11-ний өдрийн №46 дугаар албан бичиг ГБХЗХГ, Цагдаагийн газар, БСУГ, нэгдсэн эмнэлэг зэргээс гаргасан “Хүүхдийн хөгжил, хамгаалал”-ын аяны зөвлөмжийг төсвийн байгууллагуудад хүргүүлэн хэрэгжүүлж ажиллах үүргийг өгөөд байна. Зам тээврийн осол, гэмтлийн аюулаас урьдчилан сэргийлж, Төсвийн байгууллагууд хуваарьт засмал замын цасыг цэвэрлэв.

**Өндөршил сум:** . Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид 2019 оны 4-р сарын 10-ны өдөр 57,1 хувийн ирцтэйгээр хуралдаж :

1. Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн тайлан,
  2. Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх сумын 2019 оны төлөвлөгөө батлах тухай,
  3. Сумын Ерөнхий боловсролын сургуулийг АИХ-ын депутат, МУЗН-ийн ерөнхийлөгч асан Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн болон Алтан гадас одонт Нүрэнгийн Шурагийн нэрэмжит болгох саналыг уламжлах тухай,
  4. Сумын ИТХ-ын ээлжит хуралдааны товыг өөрчлөх тухай,
  5. Сумын ИТХ-ын хөдөлмөрийн дотоод журмын төслийг хэлэлцэх тухай асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэлээ.
- Хуралдаанд сумын Засаг дарга болон Хөдөлмөр, нийгмийн халамжийн мэргэжилтэн нар оролцов.

**Сайнцагаан сум:** Сайнцагаан сумын цэрэг татлага 2019.04.11-12-ны өдрүүдэд зохион байгуулагдаж комиссоор 9 багийн 242 иргэн орж 32 цэрэг тэнцэж хяналтын үзлэгээр орохоор боллоо. Энэ удаагийн цэрэг татлагын онцлог нь цэрэг бүр эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд бүрэн хамрагдаж, цэргийн насны иргэдэд батлан хамгаалах болон цэргийн албаны шинэ хуулиудаар бэлтгэсэн гарын авлага тараалаа.

Байгууллагын төрийн захиргааны 7 албан хаагчдад аймгийн ТАЗөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын хуулиудаар сургалт зохион байгууллаа.

2019.04.18-ны 14 цагт байгууллагын албан хаагчдад Санхүүгийн албаны дарга С.Отгонбямба Монгол улсын 2019 оны төсвийн тухай хууль, Сайнцагаан сумын өрхийн эмнэлэгийн Их эмч Я.Цэнд-Аюуш “Чихрийн”, “Даралт ихсэх” өвчнүүдээс урьдчилан сэргийлэх сэдвээр тус тус хуулийн сургалт хийлээ.

Сайнцагаан-Сүүн цагаан сонины энэ удаагийн дугаарыг төвийн 5 багийн мэдээллээр эх бэлтгэн хэвлэлтэнд өгөхөд бэлэн болоод байна.

ОНХСангийн талаар иргэдэд мэдээлэл өгөх, хэрхэн эрэмбэлэх талаар чиглүүлэгч багшийн сургалтанд баг бүрээс 1 иргэн хамрууллаа.

Аймгийн цэргийн штабаас цэргийн бэлтгэл 1-р үүрэгтний дайчлан татах 14 хоногийн сургалтад 7 дугаар багийн 3 иргэн, мэргэжил олгох сургалтанд 6 дугаар багийн 2 иргэн тус тус хамрагдлаа.

Мандал багийн нийгмийн ажилтан багийн аавуудад “Аав хүний үүрэг оролцоо” сэдвээр сургалт зохион байгууллаа.

Улсын бүртгэлийн хэлтсээс зохион байгуулсан” Цахим бүртгэл”-сэдэвт сургалтад ЗДТГ-ын албан хаагчид хамрагдлаа. Далай багийн засаг дарга Ж.Зоригтбаатар, жолооч Б.Батбаяр, Цагдаагийн Хэсгийн төлөөлөгч Б.Амарбаяр, Хүний эмч С.Пүрэвжав, ХАА-н ажилтан Т.Батсайхан нарын хамт Далай багт ажиллаа Энэ хугацаанд 967 км явж багийн нутагт болон Дэлгэрцогт,Дэрэн, Гурвансайханд хаваржиж байгаа нийт 143 өрхөөр орж 286 малчидтай уулзан мал хаваржилтийн байдал, малчдын амьдралтай газар дээр нь танилцан иргэдийн санал бодлыг сонсож, Мал төллөлт, төл бойжилт, цаг үеийн байдалтай танилцаж “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Малын хулгайгаас урдчилан сэргийлэх, засмал зам дагуух айлуудыг бод малд гэрэл ойлгогчтой зүүлт хийх талаар Цагдаагийн мэдээлэл хийж гарын авлага өгч санал солилцлоо. Сайнцагаан хонины омог тогтоох ээмэгжүүлэх талаар болон, үлийн цагаан оготнын тархалтын байдлын талаар малчид иргэдтэй уулзан мэдээлэл-зураглал гаргаж авлаа.

**Сайхан-Овоо сум:**“ЭКО СУРГУУЛЬ,ЦЭЦЭРЛЭГ” шалгаруулах болзолт уралдааны удирдамжийг дагаж мөрдөн ажиллаж, хүүхдэд хог хаягдлын тодорхой мэдлэг мэдээллийг өгөх зорилгоор “Хог” сэдвийн дагуу суралцахуйн 6 чиглэлээр сургалт үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. Мөн цэцэрлэгийн “Эко зөвлөл”-ийг байгуулан төлөвлөгөө гарган ажиллаж байна. Хүүхдийг хайрлаж, тэдэнд үргэлж туслаж,дэмжлэг үзүүлж байх, хүүхдийг хамгаалах талын ойлголтоо нэмэгдүүлэх зорилгоор “Хүүхдийн эрх, хамгаалалын тухай”,хуулиар арга зүйч багш нарт сургалт явуулсан.



**Хулд сум:** 1.Сумын ИТХ-ын ээлжит бус 12-р хуралдаанаар сумын 2018 ны төсвийн гүйцэтгэл батлах, 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалт өөрчлөн батлах, 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, 09/04 дугаар тогтоолын хэрэгжилт, Соёлын төвийн үзвэр үйлчилгээ, спорт заалны үйлчилгээний талаар асуудлыг холбогдох албан тушаалтнууд оруулж хэлэлцүүлсэн.

2.Удирдлагын академийн багш, доктор Гансүх тус суманд ирж “Хувь хүний хөгжлийн сургалт”-ыг төрийн хаагчдад явуулж, сертификад олгосон. Үүнд 30 гаруй хүн хамрагдсан.

3. 2.Отрын бүс нутагт нутаглаж байгаа малчин олон нийтэд ОНХСангийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сайн туршлага нэвтрүүлэх ажлын удирдамжийн дагуу бэлтгэл ажил хангаж ажиллаж байна.

4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 46 дугаар зарлиг, АЗД-ын 2019 оны 78 тоотыг хэрэгжүүлэх зорилгоор сумын албан байгууллага, ААН-ийн нэр хаягийг крилл болон үндэсний бичгээр хослуулан бичиж хаягжуулалтаа шинэчлэх талаар ЗДТГ-ын даргын 2019 оны 109 тоотыг Албан байгууллага, ААН-ийн дарга, эрхлэгч нарт хүргүүлсэн.

5. Монгол Улсын Биеийн тамир,спортын тухай хууль, Ерөнхийлөгчийн 2010 оны "Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай" 53 дугаар зарлиг, Чийрэгжүүлэх,бялдаржуулах үйлчилгээ"МNS 5538-2005 стандартын хавсралтаар батлагдсан "Хүн амын бие бялдрын хөгжил,чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорил"-ыг улс аймгийн хэмжээнд иргэдээс жил бүрийн 4 дүгээр сард тогтмол авдаг уламжлалын дагуу иргэд сорилдоо албан байгууллага, ААНэгж, багууд хуваарийн дагуу иргэдээ хамруулж эхлээд байна.

**Эрдэнэдалай сум:** Мэрэгч амьтадын тандалт судалгааг 2019 оны 4 дүгээр сарын 14-нд ХАА Ургамал хамгаалалын хүрээлэнгийн захирал Д.Бямбасүрэн, 2 мэргэжилтэнгийн хамт Дундговь аймгийн ХАА-н дарга Б.Мөнхжаргал мэргэжилтний хамт, Сумын засаг даргын тамгын газрын түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэбаатар, засаг даргын орлогч Ц.Бадамцэрэн, ХАА мэргэжилтэн Н.Нандинцэцэг, БОХ мэргэжилтэн Т. Эрдэнэзаяа нарын бүрэлдэхүүнтэй Өнгөт баг, Тэнглэг багийн нутгаар явж тандалт судалгааг хийсэн. ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн хуралдаанаар сумын хэмжээнд сар бүрийн 15, 25-ны өдрүүдэд архи согтууруулах ундаа худалдан борлуулах, үйлчлэхийг хориглосон шийдвэр гарсан. Энэхүү тогтоолыг ААН байгууллагуудад хүргүүлэн тогтоолын биелэлтэнд анхааран ажиллаж байна. Урин дулааны цаг ирж буйтай холбогдуулан орчин тойрны хог шороог цэвэрлэх, өнгө үзэмжээ сайжруулах, хөрсний бохирдлоос сэргийлэх зорилгоор Баруун Хөх Хадны арын жалга, Тэмээтийн адаг орчмын зам дагуух хог хаягдлыг цэвэрлэж хогийн цэгт ачуулав.